



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/224

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага төрийн бус байгууллагатай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажилд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг гэрээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН